

Цаг уур орчны хяналт шинжилгээний салбарын нягтлан бодогчдын сургалтын тайлан

ЦУОШГ-ын даргын 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/116 тоот тушаалаар 2017.09.21-2017.09.22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Сургалт 2017 оны төсвийн өнөөгийн байдал, төсвийн төсөл, УСННБ, ОУ-ын стандарт, Шилэн дансны мэдээ, хууль тогтоомж, түүний хэрэгжилт, 2016 оны салбарын санхүүгийн тайлан 2017 оны аудитын чиг хандлага, Төрийн өмчийн гэрээ, бүртгэх маягт, програм хангамж, 2018 оны хөрөнгийн дахин үнэлгээний чиг хандлага, бүртгэл, Сангийн яамны Э-тайлан түүний уялдаа, тэнцэл, заавар, Цаг уурын салбарын санхүүгийн ажлын үр дүн, үзүүлэлт, цаашдын зорилт сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулагдлаа.

Сургалтанд Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын төсвийн зарлагын хэлтэсийн мэргэжилтэн н.Уранцэцэг, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн н.Дариймаа, Байгал орчин, аядад жуулчдадын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Б.Одбаяр, Үндэсний аудитын газрын санхүү аудитын менежер Г.Гүнжидмаа, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ерөнхий нягтлан бодогч Д.Гүндсамбуу, ЦУОШГ-ын ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр, ЦУОШГ-ын санхүү хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн С.Сэржмядаг, ЦУОШГ-ын өмч, хамгаалалт, аж ахуй хариуцсан мэргэжилтэн Р.Эрдэнэ-Оргил нар уригдаж хичээл заасан.



